НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/330 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлсан “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг бүртгэх үйл ажиллагаатай холбоотой орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, томилох, ажиллуулах журам”-ын 2.2-т заасны дагуу уг үйл ажиллагаатай холбоотой орон тооны бус шинжээчийг нээлттэй сонгон шалгаруулалтад урьж байна.

Тавигдах шаардлага:

1.Бүртгүүлэхээр ирүүлсэн бодисын материалд үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай, дадлага, туршлагатай, мэргэшсэн (шавж, мэрэгч, нян, вирус, хор судлаач зэрэг төрөлжсөн мэргэжлээр мэргэшсэн эмч, биологич, химийн мэргэжилтэн, эрүүл ахуйч, тархвар судлаач) байх;

2.Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх;

3.Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/74 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлсан “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журам”-ын 3.7-д заасан англи эсвэл орос хэл дээрх бүртгэлийн баримт бичгийг уншиж ойлгох, мэргэжлийн үнэлгээ хийх чадвартай байх;

4.Бодис импортолдог, үйлдвэрлэдэг болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагаас хараат бус байх;

5.Ёс зүйн зөрчилгүй байх.

Эрүүл мэнд болон химийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, их, дээд сургууль, эрүүл мэндийн байгууллага, төрийн бус байгууллага нь дээрх шаардлагыг хангасан мэргэжилтнийг шинжээчид нэр дэвшүүлж болно.

Шинжээчээр ажиллах хүсэлтэй мэргэжилтэн дараах материалыг бүрдүүлж, 2026 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн ажлын цагт багтаан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын info@mmra.gov.mn цахим хаягаар эсвэл Энхтайван найрамдлын ордны 206 тоотод эмийн бүртгэлийн мэргэжилтэн Д.Туяацэцэгт цаасаар ирүүлнэ үү.

Үүнд:

1. Шинжээчээр ажиллахыг хүссэн өргөдөл, цээж зураг 1 хувь;
2. Ажиллаж буй байгууллагын тодорхойлолт;
3. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 521 дүгээр тогтоолын хавсралтаар батлсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын нэгдүгээр хавсралтын “Төрийн албан хаагчийн анкет”-ын Маягт 1-ийн дагуу бөглөсөн анкет;
4. Иргэний үнэмлэхийн хуулбар;
5. Боловсролын диплом, мэргэжлийн зэргийн үнэмлэх, мэргэшсэн сургалтын үнэмлэхийн хуулбар;
6. Ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;
7. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос гаргасан ёс зүйн зөрчилгүй тухай тодорхойлолт (Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.5 дахь заалтад заасан мэргэжилтэн хамаарна);
8. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа /E-Mongolia цахим сангаас татаж авсан, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласныг нотлох/.

Жич: Тодруулгыг ажлын цагаар 51-260232 дугаарын утсаар лавлана уу.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ